



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 06 сарын 24 өдөр

Дугаар А/АЖ.


Улаанбаатар хот

Урамшуулал олгох тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчид шагнал олгох журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албаны Тохижилт, Хог хаягдлын удирдлагын хэлтсийн Ногоон байгууламжийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн доктор /PHD/ Дашдондогийн Сүхбат нь Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөөнд ногоон байгууламжийн үндэсний 3 стандартыг шинээр боловсруулан батлуулж, ногоон байгууламжийн үйл ажиллагааг Олон Улсын ISO 9000:2015 стандартыг нэвтрүүлэх бэлтгэл ажлыг удирдан, нэг сэдэвт бүтээл 1, олон улсын өгүүлэл 2, эрдэм шинжилгээний илтгэл 23, ном, гарын авлага 3 бичиж, хот суурингийн ногоон байгууламжийн тухай хууль тогтоомжийн ажлын хэсэгт ажиллаж, хотын нэг хүнд ноогдох ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь өндрөөр үнэлж, Монголын шинжлэх ухааны үндэсний академиас Академич цол хүртсэнд тус албаны дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.10 дахь заалтын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний урамшуулал олгосугай.

2. Д.Сүхбатад олгох 640000 /зургаан зуун дөчин мянга/ төгрөгийг шагнал урамшууллын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

